



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:



Санамж:

- ✓ Монгол хэл, үндэсний бичиг, уран зохиолын 20 даалгаврыг 40 минутад гүйцэтгэх тул цагаа сайтар төлөвлөж бүх даалгаврыг ажиллаарай.
- ✓ Монгол хэлний даалгавруудыг гүйцэтгэхдээ эхийг уншиж, сайтар ойлгосон байхыг анхаараарай.

Аарц шахаж, ааруул хийх

Тогоо нэрэхдээ буцалгасан ундаагаа “цагаа” гэх ба хөрөхөөр нь цагаан цууямбуу уутанд хийн, ханын толгойноос зүүж, тосгуур хувинд шар сүүг нь шүүгээд, агшсан ууттай цагаагаа хоёр модон хавтангийн хооронд шахан, дээрээс нь хүнд чулуугаар даруулж, улам нягтаршуулан нэг хонуулна. Ингэж шар сүүг нь сайтар шахсан, бат нягтаршсан цагааг “аарц” гэнэ.

Аарцтай уутныхаа амыг маргааш өглөө нь эвтэйхэн задалж, утсаар аарцаа жигд зүсэж, тэвшин дээрээ өрж, ааруул тавина. Эмээгийн зүссэн ааруулыг модон тэвшин дээр хоорондоо салхи орох зайтай өрөх нь миний хийдэг ажил болно. Эмээ чихэртэй ааруул хийх гэсэн бол аарцаа түмпэн саванд хийж суллаад, элсэн чихэр хольж базна. Аарцандаа элсэн чихрээ уустал базсаны дараа чихэртэй ааруулаа элдэв хэв маягт оруулж хийдэг. Тасалж базсан аарцаа дугуйлж хавтгайлаад таанан дугуй хэлбэрт оруулан, тэвшин дээр өрнө.

Тэвштэй ааруулаа цагаан марлиар бүтээж, гэр дээр тавихад ялаа шавж буухгүй, нар салхинд хурдан, цэвэрхэн эвэрдэг. Ааруул хатаахад хоёр том дайсан гарч ирнэ. Эхний дайсан бол ааруулыг чийг цохиж хөгцрүүлэх явдал юм. Бороо шивэрлээ л бол ааруул норж, хатахгүй удвал доогуураа хөгцөрнө. Гэр дээр дэлгэсэн ааруулаа борооноос өмнө оруулж, тэнгэр цэлмэж, нар гарахад дахин гаргаж тавина. Ааруулын удаах дайсан бол тоонон дээгүүр жигүүрээ дэлгэн эргэлдэх элээ шувуу юм. Хааяа элээ тэвшин дээрээс ааруул шүүрнэ. Боломж гарвал хэрээ, шаазгай, улаан хошуут ирж ааруул тоншино. Гэр дээрх тэвштэй ааруулаа харж хандах хүний бараа байх хэрэг заавал гарна. Хол явахаар бол тэвштэй ааруулаа гэртээ оруулаад нар дагуулан тавихаас өөр аргагүй.

Таанан дугуй хэлбэрт оруулж дугуйлсан чихэртэй ааруулаа бүтэн эврэхээр нь бүдүүн нойлын утсаар хэлхэж, унь дагуулан өлгөнө. Эргүүлж, тойруулж байгаад сайтар **эвэрсэн** ааруулаа нимгэн цагаан ууттай бусад ааруул дээрээ нэмж хийгээд гэр дээр тавьж, голдоо чийггүй болтол нь хатаана. Харахад шалихгүй юм шиг мөртөө мөн ч их аар саар арчилгаа орж байж ааруул бий болно.

Хонины бэлчээрт ааруул хүлхэх сайхан байдаг юм. Ууталж бэлтгэсэн сарлагийн сүүний ааруул бол хот суурин газар амьдарч буй амьтан ах дүү нартаа барьдаг эмээгийн эрхэм бэлгийн нэг болдог байв.

Ш.Баатар “Миний өссөн монгол ахуй”

Монгол хэлний даалгаврууд

1. “цууямбуу” гэсэн гадаад үгийн утгыг хам орчноос зөв тайлбарласан нь аль вэ?
 - A. Нэгэн төрлийн нимгэн даавуу
 - B. Айргийн хөхүүр шиг ширэн уут
 - C. Аарц шүүх арьсан уут
 - D. Ааруул бүтээх даавуу



2. Эхийн эхлэл хэсэгт аарцны тухай ерөнхий мэдээллийг бичсэн бол гурав дахь цогцолборт юуг тайлбарласан бэ?
 - A. Ааруулаа хатаах тухай
 - B. Ааруулаа хадгалах тухай
 - C. Ааруул хийх тухай
 - D. Ааруул хамгаалах тухай

3. Аль өгүүлбэр нь эхийн гол санааг харуулж байна вэ?
 - A. Хонины бэлчээрт ааруул хүлхэх сайхан байдаг юм.
 - B. Харахад шалихгүй юм шиг мөртөө мөн ч их аар саар арчилгаа ордог юм.
 - C. Ууталж бэлтгэсэн ааруул бол эмээгийн эрхэм бэлгийн нэг болдог байв.
 - D. Шар сүүг нь сайтар шахсан, бат нягтаршсан цагааг “аарц” гэнэ.

4. “Ааруул хатаахад хоёр том дайсан гарч ирнэ.” гэсэн өгүүлбэрт байгаа “дайсан” гэх үгийг зохиолч яагаад ашигласан бэ?
 - A. Бороо, элээ хоёрт талархсан учраас
 - B. Бороо, элээ хоёроос залхсан учраас
 - C. Бороо, элээ хоёрт дургүйцсэн учраас
 - D. Бороо, элээ хоёроор бахархсан учраас

5. Дараах өгөгдлөөс “**ааруулыг хамгаалахад биед хамгийн амар арга**”-д тооцогдох хэсэг аль вэ?
 - A. тэвштэй ааруулаа цагаан марлиар бүтээнэ.
 - B. ааруулаа харж хандах хүний бараа байх хэрэг заавал гарна.
 - C. борооноос өмнө оруулж, тэнгэр цэлмэж, нар гарахад дахин гаргана.
 - D. тэвштэй ааруулаа гэртээ оруулаад нар дагуулна.

6. Зохиолч “Хол явахаар бол тэвштэй ааруулаа гэртээ оруулаад нар дагуулан тавихаас өөр аргагүй” гэж дүгнэжээ. Энэ нь аль мэдээлэлд үндэслэсэн бэ?
 - A. Эхний дайсан бол ааруулыг чийг цохиж хөгцрүүлэх явдал юм
 - B. Ааруул хатаахад хоёр том дайсан гарч ирнэ.
 - C. Гэр дээрх тэвштэй ааруулаа харж хандах хүний бараа байх хэрэг заавал гарна.
 - D. Ааруулын удаах дайсан бол тонон дээгүүр жигүүрээ дэлгэн эргэлдэх элээ шувуу юм.

7. Зохиолч ааруул хөгцөрдөг гэсний шалтгаан юу вэ?
 - A. дараагийн дайсантай учирсан болохоор
 - B. нар салхи үзэхгүй гэрт байсан учир
 - C. бороо шивэрч чийгтсэн тул
 - D. нар салхинд хэт удсан учраас

8. Ааруулыг утсаар хэлхэж, унь дагуулан өлгөсний үр дүнд юу болох вэ?
 - A. Нимгэн цагаан уутанд хийнэ
 - B. Элээ шүүрэхээс хамгаална
 - C. Бороонд норохоос хамгаална
 - D. Голдоо чийггүй сайтар эвэрнэ



9. “элсэн чихрээ” холбоо үг ямар аргаар бүтсэн бэ?
 А. Нэрийн нөхцөлөөр холбогдсон
 В. Нэг үг нөгөөдөө үндсээрээ холбогдсон
 С. Үйлийн нөхцөлөөр холбогдсон
 D. Хоёр үгийн нэг нь нөгөөдөө захирагдахгүй
10. “Боломж гарвал хэрээ, шаазгай, улаан хошуут ааруул тоншино” гэсэн өгүүлбэрийн ”-вал” холбоосны үүргийг тодорхойлоорой.
 А. Дүр байдлын үүрэгтэй.
 В. Цаг хугацааны үүрэгтэй.
 С. Зорилгын үүрэгтэй.
 D. Шалтгааны үүрэгтэй.

Үндэсний бичгийн даалгаврууд

11. “өв уламжлал” гэсэн холбоо үгийг кириллээс үндэсний бичигт зөв хөрвүүлснийг сонгоорой.

A.

ᠥᠪᠣᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ

B.

ᠥᠪᠣᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ

C.

ᠥᠪᠣᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ

D.

ᠥᠪᠣᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ

12. “хэлэхү-ийн эмүн-э үгэ-бэн тунгг-а” галигийг зөв бичсэн хэсэг аль вэ?

A.

ᠬᠡᠯᠡᠬᠦᠬᠦᠢᠨᠡᠮᠦᠨᠡᠭᠦᠭᠦᠨᠠᠭᠤᠪᠡᠨᠲᠦᠩᠭ᠎ᠠ

B.

ᠬᠡᠯᠡᠬᠦᠬᠦᠢᠨᠡᠮᠦᠨᠡᠭᠦᠭᠦᠨᠠᠭᠤᠪᠡᠨᠲᠦᠩᠭ᠎ᠠ

C.

ᠬᠡᠯᠡᠬᠦᠬᠦᠢᠨᠡᠮᠦᠨᠡᠭᠦᠭᠦᠨᠠᠭᠤᠪᠡᠨᠲᠦᠩᠭ᠎ᠠ

D.

ᠬᠡᠯᠡᠬᠦᠬᠦᠢᠨᠡᠮᠦᠨᠡᠭᠦᠭᠦᠨᠠᠭᠤᠪᠡᠨᠲᠦᠩᠭ᠎ᠠ

13. “журам” гэдэг үгийг үндэсний бичгээр зөв бичсэн үгийг олоорой.

A.

ᠵᠢᠷᠠᠮ

B.

ᠵᠢᠷᠠᠮ

C.

ᠵᠢᠷᠠᠮ

D.

ᠵᠢᠷᠠᠮ

14. Үйл үгийн хэвийн “-га” дагавартай үгийг олоорой.

A.

ᠵᠢᠷᠠᠮᠤᠯᠠᠭ

B.

ᠵᠢᠷᠠᠮᠤᠯᠠᠭ

C.

ᠵᠢᠷᠠᠮᠤᠯᠠᠭ

D.

ᠵᠢᠷᠠᠮᠤᠯᠠᠭ

15. “тул-” гэдэг үгийн олноороо үйлдэх утгыг олоорой.

A.

ᠲᠤᠯᠤ

B.

ᠲᠤᠯ

C.

ᠲᠤᠯᠤ

D.

ᠲᠤᠯᠤ

Уран зохиолын даалгаврууд

16. “Эрийн сайн Хан Харангуй” туульсын дараах хэсэгт уран дүрслэлийн ямар арга илэрч байна вэ?

Гэр нэвт гэрэлтэй

Туурга нэвт туяатай

- A. Багасгал
- B. Тойруулал
- C. Төлөөлөл
- D. Ихэсгэл

17. П. Лувсанцэрэн “Усны эргүүлэг ба борзооны явдал” туужид дайныг Чойдог багш юутай жишин, харьцуулсан бэ?

- A. Борзоон
- B. Усны эргүүлэг
- C. Хор уршиг
- D. Тэсвэр тэвчээр

18. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” туужийн энэ хэсэгт ямар хэрэг явдлын талаар өгүүлж байна вэ?

“... Манай сургууль энэ намар нэг хэсэгтээ тэр бохир эргүүлэгт орчихсон юм шиг өлсгөлөн, хулгай зэлгий, өвчин зовлонтой хутгалдаж бужигналаа. Одоогоос аюулт эргүүлгээс гарах гэж байна. Дайн дуусаж, сургууль, эмнэлэг юм бүхэн тохижиж, тэр булингартай эргүүлгээс бүр мөсөн гарах цаг мөдхөн ирнэ...”

- A. Хулгай зэлгий газар авсан тухай
- B. Дайн дажин дуусаж, сайхан цаг ирж байгаа тухай
- C. Бохир эргүүлэг сургуулийг бужигнуулсан тухай
- D. Борзоон уршиг тарьж байсан тухай

19. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг буюу Борзооны явдал” туужийн Нямжав нь дүр юм.

- A. Гол дүр
- B. Эсрэг дүр
- C. Туслах дүр
- D. Эерэг дүр



20. Д.Намдаг “Үрэгдсэнийг хүлээгч” зохиолын энэ хэсэгт дүрийг тодруулахад орчин хэрхэн нөлөөлж байна вэ?

“...Өглөө эрт аргагүй босож, гэрийн хаяанд хөмрөн хаясан хэмхэрхий араг дээр сандайлан тэнгэрийн хаяа ширтэн суужээ. Энэ өдөр бол өөрийн тооллын намрын эхэн сарын шинийн нэгний өдөр мөн бөгөөд өнөөдөр хүү ирнэ, заавал ирнэ гэж бат итгэх аж...”

- A. Хэмхэрхий араг дээр өглөө эрт суусан нь хийх юмаа олж ядсаныг илтгэж байна.
- B. Өглөө эрт босож, гэрийн хаяанд сууж байгаа нь хэн нэгнийг хүлээснийг илтгэж байна
- C. Гэрийн хаяанд хаясан хэмхэрхий араг дээр суусан нь ядуу зүдүүг илтгэж байна.
- D. Намрын эхэн сарын шинийн нэгний өдөр мөн гэж бат итгэж байгаа нь ухаан саруулыг илтгэж байна.